



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот


Албан томилолтоор ажиллуулах тухай

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дах хэсгийн 16 дугаар заалт, 15 дугаар зүйлийн 1дэх хэсгийн 1 дүгээр заалт, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 301 дүгээр тушаал, Үндэсний статистикийн хорооны Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар бүлгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Албан ёсны статистикийн мэдээллийн чанарт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлаар Дотоод аудит, мониторингийн хэлтсийн дарга Б.Саранчимэг, референт Д.Нямсүрэн нарыг 2019 оны 11 дүгээр сарын 15-аас 12 дугаар сарын 09-ний өдрүүдэд Өмнөговь, Дундговь, Төв аймагт томилон ажиллуулсугай.

2.Өмнөговь, Дундговь, Төв аймагт ажиллах томилолтын зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

3.Албан томилолтын ажлын тайланг ажлын 3 хоногт багтаан Хорооны дарга болон Тамгын газарт илтгэх хуудсаар танилцуулахыг Дотоод аудит, мониторингийн хэлтсийн дарга Б.Саранчимэгт даалгасугай.

ДАРГА  А.АРИУНЗАЯ

000412



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

□ Албан томилолтоор ажиллуулах тухай □

Статистикийн тухай хуулийн 15¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дугаар заалт, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 301 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны жолооч Т.Сумъяабазарыг 2019 оны 11 дүгээр сарын 15-аас 12 дугаар 09-ний өдрүүдэд Өмнөговь, Дундговь, Төв аймагт томилон ажиллуулсугай.

2.Өмнөговь, Дундговь, Төв аймагт ажиллах томилолтын зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

3.Албан томилолтоор ажилласан хугацааны замын хуудас, шатахууны баримтыг журмын дагуу бүрдүүлэн ажлын 3 хоногт багтаан Санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгөхийг Т.Сумъяабазарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ЦЭВЭГДОРЖ

000888